

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/23/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: <a href="mailto:Vujinkhandj@audit.gov.mn">Vujinkhandj@audit.gov.mn</a> Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016 Цахим хаяг: <a href="mailto:Tsevelmaab@audit.gov.mn">Tsevelmaab@audit.gov.mn</a></p>
---------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага .....	14
4.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦОГТ  
СУМЫН БАЯНТООРОЙ ТОСГОНЫ  
ЗАХИРАГЧ Д.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 94

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангаас зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодоогүй, татварын тодорхойлолтоор илүү, дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй, төсвийн хэмнэлтийн талаарх арга арга хэмжээг баримтлалгүй хөрөнгө бэлтгэсэн зэрэг 7.0 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна гэж заасныг зөрчсөн, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07020159

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,689,147.00</b>	<b>27,276,150.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>106,047.00</b>	<b>0.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>106,047.00</b>	<b>0.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	106,047.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>4,583,100.00</b>	<b>27,276,150.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>4,583,100.00</b>	<b>27,276,150.00</b>
35410	Бичиг хэргийн материал	513,000.00	542,100.00
35420	Аж ахуйн материал	790,600.00	18,962,550.00
35440	Түлш, шатах тослох материал	2,220,000.00	2,064,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,059,500.00	5,707,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>317,645,881.70</b>	<b>400,786,448.78</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>317,645,881.70</b>	<b>400,786,448.78</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>302,749,881.70</b>	<b>385,890,448.78</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	286,900,609.56	286,900,609.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,894,622.80	-45,352,237.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	61,580,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,437,500.00	-40,833,610.79
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	29,400,621.00	31,500,621.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,322,975.88	-24,623,225.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,615,375.50	11,615,375.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,395,375.50	-10,270,375.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	51,600,000.00	132,767,450.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,716,250.18	-17,394,157.73
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>14,896,000.00</b>	<b>14,896,000.00</b>
39301	Програм хангамж	1,195,800.00	1,195,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,195,800.00	-1,195,800.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,896,000.00	14,896,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>322,335,028.70</b>	<b>428,062,598.78</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>322,335,028.70</b>	<b>428,062,598.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>322,335,028.70</b>	<b>428,062,598.78</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,632,979.09	44,632,979.09
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>47,290,112.89</b>	<b>153,017,682.97</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	30,698,554.13	47,290,112.89
51220	Тайлант үеийн үр дүн	16,591,558.76	105,727,570.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,411,936.72	230,411,936.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>322,335,028.70</b>	<b>428,062,598.78</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>161,730,900.00</b>	<b>294,868,167.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,470,000.00</b>	<b>128,951,067.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>32,470,000.00</b>	<b>128,951,067.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>32,470,000.00</b>	<b>128,951,067.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	720,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	32,470,000.00	105,259,117.00

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		22,971,950.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>129,260,900.00</b>	<b>165,917,100.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,960,000.00</b>	<b>4,610,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,860,000.00	4,610,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>126,300,900.00</b>	<b>161,307,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,300,900.00	161,307,100.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>145,139,341.24</b>	<b>189,140,596.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>145,139,341.24</b>	<b>189,140,596.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>142,266,669.24</b>	<b>171,479,026.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>77,004,390.00</b>	<b>72,182,392.00</b>
210101	Үндсэн цалин	53,660,390.00	49,962,669.00
210104	Урамшуулал	6,400,000.00	3,996,633.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,944,000.00	18,223,090.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,108,706.00</b>	<b>9,473,184.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,145,235.00	6,653,979.30
210202	Тэтгэмжийн даатгал	816,703.00	739,582.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	643,283.00	574,866.04
210204	Ажилгүйдлийн даатгал	153,832.00	136,796.65
210205	Эрүүл мэндийн даатгал	1,349,653.00	1,367,959.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,839,379.00</b>	<b>11,046,850.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,091,879.00	1,090,850.00
210302	Түлш, халаалт	6,747,500.00	9,956,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,793,540.60</b>	<b>16,621,350.00</b>
210401	Бичиг хэрэг	1,284,000.00	1,330,400.00
210402	Тээвэр, шатахуун	10,692,600.00	12,541,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	260,000.00	700,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	699,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,534,200.00	1,349,300.00
210408	Бараа материал акталсны зардал	3,822,740.60	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,360,000.00</b>	<b>1,899,600.00</b>
210502	Хоол, хүнс	700,000.00	799,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,660,000.00	1,100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>999,600.00</b>
210604	Урсгал засвар	0.00	999,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>940,000.00</b>	<b>810,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	940,000.00	810,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,556,793.00</b>	<b>30,159,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,840,000.00	29,624,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	125,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	64,793.00	60,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,663,860.64</b>	<b>28,286,549.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,001,000.00	5,664,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	372,660.00	503,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,290,200.64	22,118,549.92
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,872,672.00</b>	<b>17,661,570.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,500,000.00</b>	<b>3,800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	3,800,000.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	372,672.00	13,861,570.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	372,672.00	13,861,570.74
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	16,591,558.76	105,727,570.08
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	16,591,558.76	105,727,570.08

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	30,698,554.13	305,743,469.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	30,698,554.13	305,743,469.94
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	16,591,558.76	16,591,558.76
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	47,290,112.89	322,335,028.70
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	47,290,112.89	322,335,028.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	47,290,112.89	322,335,028.70
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	105,727,570.08	105,727,570.08
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	153,017,682.97	428,062,598.78

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	129,260,900.00	166,743,147.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	826,047.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	826,047.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	826,047.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	720,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	106,047.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	129,260,900.00	165,917,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,960,000.00	4,610,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,860,000.00	4,610,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.00	0.00

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>126,300,900.00</b>	<b>161,307,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,300,900.00	161,307,100.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>126,760,900.00</b>	<b>166,743,147.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>126,760,900.00</b>	<b>166,743,147.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>123,888,228.00</b>	<b>149,081,576.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>77,004,390.00</b>	<b>72,182,392.00</b>
210101	Үндсэн цалин	53,660,390.00	49,962,669.00
210104	Урамшуулал	6,400,000.00	3,996,633.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,944,000.00	18,223,090.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,108,706.00</b>	<b>9,473,184.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,145,235.00	6,653,979.30
210202	Тэтгэмжийн даатгал	816,703.00	739,582.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	643,283.00	574,866.04
210204	Ажилгүйдлийн даатгал	153,832.00	136,796.65
210205	Эрүүл мэндийн даатгал	1,349,653.00	1,367,959.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,891,379.00</b>	<b>10,892,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,091,879.00	1,092,000.00
210302	Түлш, халаалт	6,799,500.00	9,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,293,300.00</b>	<b>16,857,300.00</b>
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	1,359,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,692,600.00	12,540,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	260,000.00	700,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,840,700.00	1,557,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,360,000.00</b>	<b>1,899,600.00</b>
210502	Хоол, хүнс	700,000.00	799,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,660,000.00	1,100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>999,600.00</b>
210604	Урсгал засвар	0.00	999,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>940,000.00</b>	<b>810,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	940,000.00	810,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,556,793.00</b>	<b>30,159,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,840,000.00	29,624,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	125,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	64,793.00	60,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,733,660.00</b>	<b>5,808,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,361,000.00	5,304,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	372,660.00	503,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,872,672.00</b>	<b>17,661,570.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,500,000.00</b>	<b>3,800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	3,800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>372,672.00</b>	<b>13,861,570.74</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	372,672.00	13,861,570.74
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,500,000.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,500,000.00</b>	<b>0.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,500,000.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,500,000.00</b>	<b>0.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,500,000.00	0.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,500,000.00</b>	<b>0.00</b>

VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>161,307,100.00</b>	<b>148,271,576.26</b>	<b>13,035,523.74</b>	92%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>161,307,100.00</b>	<b>148,271,576.26</b>	<b>13,035,523.74</b>	92%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>157,807,100.00</b>	<b>144,771,576.26</b>	<b>13,035,523.74</b>	92%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>78,862,000.00</b>	<b>72,182,392.00</b>	<b>6,679,608.00</b>	92%
210101	Үндсэн цалин	53,426,000.00	49,962,669.00	3,463,331.00	94%
210104	Урамшуулал	7,042,000.00	3,996,633.00	3,045,367.00	57%
210105	Гэрээт ажлын хөлс	18,394,000.00	18,223,090.00	170,910.00	99%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,086,200.00</b>	<b>9,473,184.26</b>	<b>1,613,015.74</b>	85%
210201	Тэтгэврийн даатгал	7,807,600.00	6,653,979.30	1,153,620.70	85%
210202	Тэтгэмжийн даатгал	819,800.00	739,582.51	80,217.49	90%
210203	ҮОМШӨ-ний даатгал	655,700.00	574,866.04	80,833.96	88%
210204	Ажилгүйдлийн даатгал	163,900.00	136,796.65	27,103.35	83%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,639,200.00	1,367,959.76	271,240.24	83%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,892,000.00</b>	<b>10,892,000.00</b>	<b>0.00</b>	100%
210301	Гэрэл, цахилгаан	1,092,000.00	1,092,000.00	0.00	100%
210302	Түлш, халаалт	9,800,000.00	9,800,000.00	0.00	100%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,347,300.00</b>	<b>15,347,300.00</b>	<b>0.00</b>	100%
210401	Бичиг хэрэг	1,250,000.00	1,359,500.00	-109,500.00	109%
210402	Тээвэр, шатахуун	11,200,000.00	11,090,500.00	109,500.00	99%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,000.00	700,000.00	0.00	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00	0.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,497,300.00	1,497,300.00	0.00	100%
2105	<b>Нормативт зардал</b>	<b>1,899,600.00</b>	<b>1,899,600.00</b>	<b>0.00</b>	100%
210502	Хоол, хүнс	799,600.00	799,600.00	0.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	1,100,000.00	0.00	100%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>999,600.00</b>	<b>400.00</b>	100%
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,600.00	400.00	100%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,337,000.00</b>	<b>810,000.00</b>	<b>527,000.00</b>	61%
210702	Дотоод албан томилолт	1,337,000.00	810,000.00	527,000.00	61%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,575,000.00</b>	<b>27,359,500.00</b>	<b>4,215,500.00</b>	87%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,040,000.00	26,824,500.00	4,215,500.00	86%

210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,000.00	125,000.00	0.00	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	0.00	100%
210807	Газрын төлбөр	60,000.00	60,000.00	0.00	100%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,808,000.00</b>	<b>5,808,000.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,304,900.00	5,304,900.00	0.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	503,100.00	503,100.00	0.00	100%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,500,000.00</b>	<b>3,500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,500,000.00</b>	<b>3,500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00	0.00	100%
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>161,307,100.00</b>	<b>148,271,576.26</b>	<b>13,035,523.74</b>	<b>92%</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>161,307,100.00</b>	<b>147,445,529.26</b>	<b>13,861,570.74</b>	<b>91%</b>
320001	Орон нутгийн төсвөөс	161,307,100.00	147,445,529.26	13,861,570.74	91%
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>826,047.00</b>	<b>-826,047.00</b>	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	720,000.00	-720,000.00	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	106,047.00	-106,047.00	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>10.00</b>	<b>10.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	100%

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>4,610,000.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	4,610,000.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	4,310,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1,510,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		60,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	2,800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	300,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		300,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>4,610,000.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,610,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,610,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж

заасны дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын алба нь Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 163.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32.8 хувиар буюу 105.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27.3 сая төгрөг болж 22.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 36.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүй 23.0 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 35.1 сая төгрөгийн материалыг зарцуулж, 1.9 сая төгрөгийн материалыг шилжүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 540.5 төгрөг болж 124.8 сая төгрөгөөр өссөн нь 124.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 428.1 сая төгрөг болж 105.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 82.3 хувиар буюу 133.1 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 153.0 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 143.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 17.5 сая төгрөгөөр нэмж, 161.3 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг нэмж баталсантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 161.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 161.3 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанаас 0.8 сая төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 148.3 сая төгрөгийг зарцуулж 13.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 148.3 сая төгрөг буюу 92 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 6.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.6 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 0.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг 4.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 6.3 сая төгрөгийн орлого хүлээн авч, 5.8 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд, 0.3 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 0.02 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллээс 133 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 13 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.0 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 5.6 сая төгрөгийн зөвлөмжийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан байна.

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар эд хөрөнгийн тооллого, тээвэр шатахууны зардал, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй. Хүнс, хөдөө аж ахуйн газраас өвс, тэжээл тээвэрлэх 1.3 сая төгрөгийн тээвэр, шатахууны зардлыг нэмэлт санхүүжилтийн олгож зарцуулсан боловч бараа материалын тайланд орлого авч зарцуулаагүй, иргэдэд шууд худалдан борлуулж, хандиваар өгсөн байна. Захирагчийн ажлын албаны 1 мэргэжилтэн Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцээгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.4 сая төгрөгийн алдааг залруулж, 7.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайланг 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Нэмэлт санхүүжилтийн төсвийн хэлбэлзэл 1.3 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг аймгийн Төрийн санд хандаж засварлуулахаар тохиролцов. Зардлыг түүвэрлэн үзэхэд 4.9 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

### 4.3 Албан шаардлага

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангаас 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд

хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй 1.1 сая төгрөгийн ажлын хувцас бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т "автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 4.7 сая төгрөгийн илүү, 0.6 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны ЗАА	6	13.4	2	6.4	0	0	4	7.0	0	0